

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ
ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 07 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-д заасны дагуу Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн тайланд явцын хяналт-шинжилгээ хийж, дүнг танилцуулж байна.

Үнэлгээний зорилго нь Улсын бүртгэлийн байгууллагын зохион байгуулалтын нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жилийн байдлаар явцын үнэлгээ хийж үр дүнг хэмжих, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нэгжүүдийн хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, ил тод байдлыг хангахад оршино.

Нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний явцын үнэлгээг хяналт-шинжилгээний асуудал хариуцсан газраас 3 хүний бүрэлдэхүүнтэй баг хийсэн ба бодлогын баримт бичгийн үр нөлөөтэй байгаа эсэхийг нягталж, үйл ажиллагаагаа сайжруулахын тулд шинэчлэл, өөрчлөлт хийхэд шаардлагатай мэдээллийг гаргах, нэгжүүд төлөвлөлтөө дахин харж сайжруулах боломжийг олгох, үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшний тоон утга, хэрэгжих хугацаа, шаардлагатай хөрөнгийг урьдчилан тооцоолсон эсэхэд тоон өгөгдөл, мэдээлэл цуглуулах, хийгдсэн үйл ажиллагаа, ажилбаруудыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх аргачлалыг ашигласан.

Тус хэлтэс нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 49 арга хэмжээ тусган хэрэгжилтийг дараах байдлаар ханган ажилласан байна.

Арга хэмжээний гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Арга хэмжээ	Үнэлгээ					Дундаж хувь
	Хугацаа болоогүй	0-29	30-59	60-84	85-100	
49		2	4	23	20	81.8

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнүүд:

Дд	№	Заалт	%	Үнэлгээний тайлбар
1	1.1	Шинээр хэрэглээнд нэвтрүүлсэн Улсын бүртгэлийн цахим гэрчилгээгээр иргэд олон нийтэд үйлчилгээ үзүүлэх	0	Бодлогын газраас чиглэл авч төлөвлөх ёстой. Хууль дүрэм журам батлагдаагүй байхад төлөвлөсөн байна.
2	1.5	Шинээр үйл ажиллагаанд нэвтрүүлсэн гадаад паспорт захиалгын цахим машиныг орон нутагт хэрэглээнд нэвтрүүлэхэд сумдын удирдлагуудтай уулзалт зохион байгуулах, сурталчлан таниулах	50	Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй.
3	1.6	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг харъяалал харгалзахгүй бүртгэх талаар ирүүлсэн чиглэлийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх	0	Тайлагналт буруу.
4	2.10	Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийх	66.9	УБЕГ-н2025 оны эрсдлийн төлөвлөгөөтэй уялдуулсан эсэх

Дүгнэлт, зөвлөмж

Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн тайланд явцын хяналт-шинжилгээ хийж, эхний хагас жилийн байдлаар биелэлтийг 81.8 хувь буюу “**Үр дүн хүлээгдэж байгаа**” гэж дүгнэв.

Тайлант оны үлдсэн хагаст дараах асуудалд анхаарч, үйл ажиллагааг сайжруулахыг зөвлөж байна:

1.Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг тайлант оны үлдсэн хугацаанд эрчимжүүлэх, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтэд хүрч ажиллах, нэгжүүд төлөвлөлт хийх явцад чиг үүргийн газруудаас зөвлөмж чиглэл авч төлөвлөөгүйгээс зарим нэг арга хэмжээний биелэлт тасарсан байгааг анхаарах;

2.Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн байгууллагад иргэдээс гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж хэрэгжилтийг үнэлж, дүгнэх;

3. Хэлтсийн төлөвлөгөөнд тусгагдсан өгөгдлийн шинжилгээ хийх гэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хоёр болон түүнээс олон хувьсагчийн хоорондын хамаарал байгаа эсэх байгаа бол ямар хамаарал байгаа, түүнээс гарсан үр дүнд тулгуурлан авч хэрэгжүүлсэн ажлын талаар тайлагнах;

4.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд чиг үүргийн газруудын төлөвлөсөн арга хэмжээг шууд төлөвлөж оруулсан нь арга хэмжээний биелэлт тасрах, хангалтгүй хэрэгжих гол хүчин зүйл болж байна. Цаашид төлөвлөлтийг хийхдээ чиглэлийн газраас зөвлөмж чиглэл авч төлөвлөгөөнд тусгаж байх;

5. Төлөвлөгөөнд тусгагдсан зарим нэг арга хэмжээг шалгуур тус бүрээр үнэлж тайланг ирүүлсэн байна. Арга хэмжээг үнэлэхдээ шалгууруудын нийлбэрээр үнэлэхийг анхаарах;

6.Улсын бүртгэлийн байгууллагын эрсдэлийн төлөвлөгөөний дагуу үлдсэн хугацаанд төлөвлөлтийг зөв тодорхойлж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

7.Жилийн эцэст гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ тухайн ажил үйлчилгээ шалгуур үзүүлэлтээ бүрэн хангаж, хүрэх түвшиндээ хүрсэн эсэх, хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар, гарсан үр дүн, нөлөөлөх хүчин зүйл зэрэг асуудлаа тодорхой, оновчтой тайлагнаж, нотломжийг арга хэмжээ тус бүрээр ирүүлэх;

8. Хагас жилийн үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн талаар нотломжийн хамт 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газарт ирүүлэх.

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР